


**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ДНБ, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ХУДАЛДАА, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ**


**ДНБ 2013 оны 3 улиралд өсөлттэй байна**

ДНБ (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 3 дугаар улиралд өнгөрсөн оны мөн үеэс 11.9% өссөн. Өмнөх улирлуудад 7.1%, 14.3% тус тус өссөн билээ. Энэ оны эхний 3 улирлын байдлаар ДНБ (2005 оны зэрэгцүүлэх үнээр) өнгөрсөн оныхтой харьцуулбал 11.5% өссөн. ДНБ (оны үнээр) өссөн дүнгээр 12.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 22.1% өсөхөд аж үйлдвэр, барилгын салбарын өсөлт нөлөөлөв.




**Улсын нэгдсэн төсөв алдагдалтай**

2013 оны Улсын нэгдсэн төсвийн орлого өссөн дүнгээр 5,880, зарлага 6,177 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 297 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Энэ нь 2012 онтой харьцуулахад орлого 20.5%, зардал 2.2% өссөн дүн юм. Орлогын өсөлтөнд урсгал орлого 21.5% (үүнд татварын орлого 20.5% буюу 855 тэрбум төг., татварын бус орлого 28.6% буюу 182 тэрбум төг. өссөн) өссөн нь нөлөөлөв. Зарлагын бага зэргийн өсөлт нь хөрөнгийн зардлын 4.6% буюу 63 тэрбум төгрөгийн өсөлттэй холбоотой юм.



**Гадаад худалдааны алдагдал 2 тэрбум ам.доллар**

2013 оны нийт барааны эргэлт өмнөх оны мөн үеэс 4.5% буурч 10.6 тэрбум ам.доллар болжээ. Экспорт 2.6%, импорт 5.7% буурснаас гадаад худалдааны алдагдал 2 тэрбум ам.долларт хүрэв. Экспортонд гаргасан чулуун нүүрсний үнийн дүн 1.1 тэрбум ам. долларт ( биет хэмжээгээрээ 18.2 сая тонн юм) хүрч өнгөрсөн оны мөн үеэс 41% буурав. Харин зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн экспортын үнийн дүн 949 ба 654 сая ам. долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13%, 23% өссөн байна.




**Төгрөгийн жилийн дундаж ханш сулрав**

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 12 сард нэг ам.доллар дундажаар 1,674 төгрөгтэй тэнцүү байсан нь өмнөх сарынхтай харьцуулахад 3.4% буурч, өнгөрсөн оны мөн үеэс 19.9% өндөр үзүүлэлт юм. 12 сарын 2-нд Монгол банкны өдрийн зарласан ханш 1742.06 хүрч байлаа. Гадаад валютын нийт албан нөөц 2 тэрбум 248 сая ам.доллар болсон нь өнгөрсөн сарынхаас 2.7%, өмнөх оны мөн үеэс 45.5% буурсан үзүүлэлт боллоо.



**Инфляц 12.5%**

Хэрэглээний үнийн улсын индекс 12 дугаар сард 12.5% болжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгжээр бага үзүүлэлт юм. Инфляц өмнөх сарынхаас 1.3% өсөхөд хүнсний бараа, ундаа, ус болон хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүнгийн өсөлт нөлөөлөв. Жилийн 12.5% хүрэхэд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүнгийн өсөлтөөс гадна боловсролын үйлчилгээ өссөн нь голлон нөлөөлөв.




Эх сурвалж: УЦХ, МБ

**САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ**


**Мөнгөний нийлүүлэлт (M2) 9.4 их наяд төгрөг**

M2 мөнгө өнгөрсөн сарынхаас 3.8% өсөж 9.4 их наяд төгрөг (5.2 тэрбум ам.доллар) болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 24.1% нэмэгдсэн үзүүлэлт юм. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх сарынхаас 4.6%, өнгөрсөн оныхоос 1.5% өсөж 841 тэрбум төгрөг болсон нь нийт мөнгөний 8.9%-ийг эзэлж байна.




**Нийт хадгаламж өсөв**

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх сарынхаас 5.8% өсөж 6.4 их наяд төгрөгт (3.4 тэрбум ам.доллар) хүрч өмнөх оны мөн үеэс 29.9% буюу 1.47 их наяд төгрөгөөр өсөв. Нийт хадгаламжийн 4.9 их наядыг төгрөгийн хадгаламж, үлдсэн 1.5 их наядыг валютынх эзэлж байна. Төгрөгийн хадгаламж өмнөх сарынхтай харьцуулахад 6.2%, харин валютынх 4.7% өссөн бол өмнөх оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 41%, валютынх 2.9% өсөв.



**Чанаргүй зээлийн хэмжээ өсөв**

Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сарынхаас 1.1% буурч, өнгөрсөн оныхоос 91.8% өсөж 566 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь нийт зээлийн 5.3%-ийг эзэлж байна. Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 0.5% буурч, өнгөрсөн оны мөн үеэс 54.1% нэмэгдэж, 10.7 их наяд төгрөг (6.2 тэрбум ам.доллар) боллоо. Банкуудын төгрөгийн болон валютын зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) өмнөх жилийнхээс 0.8 нэгжээр тус тус буурч, жилийн хүү төгрөгийнх 17.4%, валютынх 12.7% болов.



Эх сурвалж: УСХ, МБ

**Сарын онцлох үйл явдал**

- > Монгол Улсын Хөгжлийн банк Япон улсын зах зээл дээр "Самурай" бондыг арилжаалав.
- > "Фитч Рейтингс" компани Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг "В+" хэмээн үнэлж урт хугацааны гадаад болон дотоод валютын үнэт цаас гаргагчийн дампуурлын эрсдлийн (ҮЦГДЭ) зэрэглэлийг тогтвортойгоос сөрөг гэсэн ангилалд шилжүүлэв. Улсын дээд хязгаарыг "В+" хэмээн бататгаж, богино хугацааны гадаад валютын ҮЦГДЭ-г "В" гэж үнэлэв. Гадаад болон дотоод валютаар нээлттэй гаргасан Монгол улсын бондыг "В+" хэмээн бататгав.
- > Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн яам санаачлан "Монгол, Орос, Хятад гурван улсыг дамнанас төмөр замын тээврийн "Умард коридор" сэдэвт гурван талт анхдугаар зөвлөгөөнийг хийв.
- > "Монголын ипотекийн корпораци" ХХК-ийн охин компани болох "МИК Актив Нэг" нь арилжааны банкуудын үл хөдлөх хөрөнгийн зээлийн багцыг худалдан авч, тус хөдлөх хөрөнгөөр баталгаажсан 328 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 3.28 сая энгийн болон давуу эрхтэй баталгаат үнэт цаасыг гаргах болов.

**Хураангуй**

2013 оны Улсын нэгдсэн төсвийн орлого өссөн дүнгээр 5,880, зарлага 6,177 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 297 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Энэ нь 2012 онтой харьцуулахад орлого 20.5%, зардал 2.2% өссөн дүн юм. Орлогын өсөлтөнд урсгал орлого 21.5% өссөн нь (үүнээс татварын орлого 20.5% буюу 855 тэрбум төг., татварын бус орлого 28.6% буюу 182 тэрбум төг.) нөлөөлөв. Ийнхүү татварын орлого 855 тэрбум төгрөгөөр өсөхөд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 26% буюу 136 тэрбум төгрөг, хүн амын орлогын албан татвар 29% буюу 102 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 25% буюу 175 тэрбум төгрөг, нэмэгдсэн өргийн албан татвар 11% буюу 146 тэрбум төгрөг, онцгой албан татвар 43% буюу 137 тэрбум төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлэв. Өмнөх оныхтой харьцуулахад татаас ба шилжүүлэг 16% буюу 358 тэрбум төгрөгөөр буурсан нь зарлагыг бууруулсан юм. Гэсэн ч цалин, хөлс 12% буюу 151 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 113% буюу 144 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгийн зардал 51% буюу 82 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь зардлыг өндөр хэвээр үлдээжээ.

2013 оны нийт барааны эргэлт өмнөх оны мөн үеэс 4.5% буурч 10.6 тэрбум ам.доллар болжээ. Экспорт 2.6%, импорт 5.7% буурснаас гадаад худалдааны алдагдал 2 тэрбум ам.долларт хүрэв. Эрдэс бүтээгдэхүүний экспорт 10.6% буюу 415 сая ам. доллараар буурсан ба нийт экспортод эзлэх хувь нь 2012 онд 89.2% байснаас 2013 онд 81.8% болж буурав. Хэдийгээр экспортод гаргасан ээсийн баяжмал болон төмрийн хүдрийн үнийн дүн 949 сая ба 654 сая ам. долларт хүрч 13% ба 23% өсөлттэй байсан ч чулуун нүүрсний үнийн дүн 1.1 тэрбум ам. долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал 41% буюу 779 сая ам. доллараар буурсан байна. Импортын бууралт нь оруулж ирсэн машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, тэдгээрийн сэлбэг, эд ангийн үнийн дүн 15.6% буюу 257 сая ам. доллараар буурсантай холбоотой. Түүнчлэн авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 21% буюу 271 сая ам. доллараар буурсан байна.